

ИРГЭДИЙН АНХААРАЛД!

Written by stockholm

Wednesday, 12 September 2018 08:50 - Last Updated Tuesday, 25 June 2019 12:57

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 9.5 -д “Гадаадад удаан хугацаагаар болон цагаачлан суугаа Монгол Улсын иргэн тус улсын дипломат толоологчийн болон консулын газарт хаягийн бүртгэл хийлгэж байх үүрэгтэй” гэж заасан байдаг. Энэхүү хуулийн заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор ГХЯ, ХЗДХЯ, ҮСХороо хамтран гадаадад оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийг бүртгэх програм боловсруулан нэвтрүүлээд байна.

Хилийн чанадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн бүртгэл мэдээллийг бий болгож, тогтмолжуулснаар иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, эрх нь зорчигдсон тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлэх, иргэний бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах суурь мэдээллийн санг бий болох ач холбогдолтой юм.

Иймд иргэн та доор дурдсан хаягаар орж бүртгэлд хамрагдана уу.

<http://www.citizen.gov.mn/>

Та оорийн мэдээллээ бүртгүүлэхээс гадна, мэдээллээ засварлах, мон гадаадад хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдээ бүртгүүлэх боломжтой.

Та бүртгүүлэхдээ оорийн олон нийтийн сүлжээ болох Facebook мон Google account-ын хаягаар орж бүртгүүлэх боломжтой.

Мон Та Үндэсний статистикийн хорооноос олгож буй Монгол улсын хэд дэх иргэн болж мэндэлснийг тань гэрчлэх батламжийг авах боломжтой.

ИРГЭДИЙН АНХААРЛД!

Written by stockholm

Wednesday, 12 September 2018 08:50 - Last Updated Tuesday, 25 June 2019 12:57

